



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЗАВХАН АЙМГИЙН ИХ-УУЛ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.21

№

440

танай

-ны №

-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн бие даан нэр дэвшигч Бямбасүрэнгийн Бүдбазарын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бямбасүрэнгийн Бүдбазарын /РД:И396010714/ Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга

хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Б.Бүдбазарын мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Б.Бүдбазарт

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР




Д.БАТ-УНДРАА

Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-д бие даан нэр дэвшигч Б. Будбазар
мөрийн хөтөлбөр

**УРИА:ХАМТРАН АЖИЛЛАЯ
ХАМТРАН ХӨГЖЬЕ**

1. Иргэдийн оролцоотой орон нутгийн засаглал

- ❖ Иргэнээ дээдэлсэн төрийн үйл ажиллагааг дэмжинэ, төрийн байгууллагуудын хүнд сурталыг арилгаж иргэдэд нээлттэй ил тод ажилах тал дээр хамтран ажиллана.
- ❖ Сум орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажилгаанд оролцох иргэдийн оролцоог дэмжиж, төрийн байгууллагуудын аливаа шийдвэрийг ил тод мэдээлүүлэх талд дээр хамтран ажиллана.
- ❖ Сум орон нутагт ажилаж буй төрийн байгууллагуудын төсвийн ил тод байдлыг хангуулан ажиллах бөгөөд дэмжлэг үзүүлэх.
- ❖ Аливаа ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах үйл явцыг ил тод байлгана.
- ❖ Аливаа төсөл хөтөлбөр тэдгээрийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтийн талаарх явцыг ард иргэдэд ил тод болгох талаар ИТХ-аар шийдвэрлүүлнэ.
- ❖ Сум хөгжүүлэх ойрын, дунд, хэтийн төлөвлгөө боловсруулах үйл ажилд санаачлагатай оролцож хэрэгжилтийг хангуулна.
- ❖ Албан байгууллагуудын дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавина.
- ❖ Сумын ИТХ-ын хуралдааныг олон нийтэд нээлттэй шууд дамжуулах арга замыг эрэлхийлэн иргэдэд олон нийтийн сүлжээгээр шууд дамжуулан хүргэх нөхцлийг бий болгоно.



2. Иргэний оролцоотой байгаль хамгаалал

- ❖ Хог цэвэрлэх тогтмол нэг өдрийг сар бүр бий болгох талаар иргэдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.
- ❖ Ойн цэвэрлэгээ болон мод бэлтгэх ажилд хяналт тавих иргэдийн баг бүрдүүлэн ажиллах бөгөөд иргэдийн хурал болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааг байгаль хамгаалах асуудалд илүү хандуулан ажиллана. Ойн санг нөхөн сэргээх ажлыг дэмжиж хамтран ажиллана.
- ❖ Байгаль орчинд ноцтой хохирол учруулж буй аливаа үйл ажиллагааг тасалан зогсооно.
- ❖ Орон нутгийн тусгай хамгаалалтанд тодорхой газар нутгуудыг хамруулна.
- ❖ Булаг усны эхийг хашаалах ажлыг дэмжинэ.
- ❖ Эко аялал жуулчлалтай холбоотой үйл ажлыг дэмжинэ, мөн сөрөг үр дагаварыг арилгах ажлыг төрийн байгууллага болон иргэдийн оролцоотойгоор шийдвэрлүүлэнэ.

3. Иргэнээ дэмжсэн боловсрол сургалт,

- ❖ Насан туршийн боловсролын тогтолцооны хамрах хүрээг өргөжүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх ажилд түлхүү анхаарна.
- ❖ Иргэдэд нээлттэй үйлчлэх **НОМ** хөтөлбөрийг соёлын төвтэй хамтран хэрэгжүүлнэ.
- ❖ Хүүхдийн хүмүүжилд анхаарч эцэг эхчүүдтэй хамтран ажиллах хөтөлбөр боловсруулж сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.
- ❖ Сумын төвийн тодорхой газруудад хүүхдийн тоглоомын талбай нэмж байгуулах ажлыг сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулна.
- ❖ Сумын сургуультай хамтран зуны улиралд бага ангийн сурагчидад зориулсан гэр сургууль ажиллуулах ажил зохион байгуулна.
- ❖ ЕБС-ийн сурагчдын сурлага, урлаг спортын амжилт гаргах тал дээр орон нутгаас хэрэгжүүлж болох нөөц боломжинд тулгуурласан арга хэмжээнүүдийг санал санаачлагатайгаар дэмжин ажиллах болно.

4. Иргэнлүү чиглэсэн эрүүл мэнд


- ❖ Эмчилгээ оншилгооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэмэгдүүлэх ажлыг дээд газарт уламжлан шийдвэрлүүлнэ.
- ❖ Сумын эмнэлэгтэй хамтран жил бүр 1-ээс доошгүй удаа явуулын эмнэлэгийн үйлчлэлгээ үзүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.
- ❖ ЭМД-аар олгох хөнгөлөлттэй эмийг түгээх ажлыг хүртээмжтэй болгох тал дээр эмнэлэг болон эмийн сангуудтай хамтран ажиллаж хөдөө орон нутагт олдоц муутай эмийн олголтыг нэмэгдүүлнэ.
- ❖ Эмнэлэгийн үйл ажиллагаа ба аливаа хүнд суртлыг арилгах тал дээр холбогдох байгууллага албан тушаалтан ажилчдыг хамарсан хөтөлбөр боловсруулж ИТХ-р дэмжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллуулна.
- ❖ Сумын ЭМТ-тэй хамтран зуны улиралд рашаан сувилалын үйлчилгээг иргэдэд хүргэх ажил зохион байгуулна.

5. Иргэдийн ажил эрхлэлт

- ❖ Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан болон бусад төсөл хөтөлбөрүүдийн үйл ажилагааг ил тод нээлттэй болгон хянаж ажиллана.
- ❖ Сум орондоо жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан эрхлэж буй хүмүүсийг дэмжих бодлого боловсруулан ИТХ-аар батлуулан ажил хэрэг болгон ажиллуулна.
- ❖ Ил задгай гудамж талбайд худалдаа хийж буй иргэдэд хяналт тавьж ажилах. Журам боловсруулан мөрдлөг болгоно.
- ❖ Малын тэжээл тариалах ажлыг дэмжинэ.
- ❖ Сум орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудтай хамтран ажиллаж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
- ❖ Мал төллөх үед ахлах ангийн сурагчидыг илгээлтийн эзэд хэлбэрээр ажлуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

6. Ахмад ба залуу үеийн холбоо

- ❖ Ахмадын байр болон ахмадын сувилалын ажлыг тогтмолжуулах тал дээр холбогдох байгууллагуудыг татан оролцуулж ажлын биелэлтийг хангуулах тал дээр онцгой ач холбогдол өгч ажиллана. Ахмадын сувилалыг ажиллуулах ажлын хэсгийн бүтээлч ажлыг дэмжинэ.
- ❖ Залуусыг дэмжих тэдний хөгжилд зориулсан соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд тухайн сум өөрийн онцлогт нь тохирсон цогц хөтөлбөр боловсруулж ИТХ-аар хэлэлцүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:  Б.Бүдбазар

